

33. ГАЗАР ДООР БУЮУ УУРХАЙД АЖИЛЛАГСДЫН НАСНЫ ДООД ХЯЗГААРЫН ТУХАЙ 124 ДҮГЭЭР ЗӨВЛӨМЖ

Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,
Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1965 оны зургаадугаар дугаар сарын 2-нд Женев хотноо зарлан хуралдуулсан өөрийн 49 дэх удаагийн чуулганаараа,

Газар доор буюу уурхайд ажиллах хүмүүсийн насны доод хязгаарын тухай 1965 оны конвенцийг баталж,

Чуулганы хэлэлцэх хэргийн төлөвлөгөөний 4 дэх асуудал болсон газар доор буюу уурхайд ажиллагсдын насны доод хязгаарын тухай тодорхой саналуудыг Зөвлөмжийн хэлбэрээр хэлэлцэж,

нэг мянга есөн зуун жаран таван оны зургаадугаар сарын хорин хоёрны өдөр дараахь Конвенцийг Газар доор буюу уурхайд ажиллах хүмүүсийн насны доод хязгаарын тухай 1965 оны зөвлөмж гэж нэрлэхээр тогтож батлав.

1. (1). Энэхүү Конвенцийн зорилгод “уурхай” гэдэг нэр томъёо нь хүний хөдөлмөрийн хүчний тусламжтайгаар газрын гүнээс ямар нэг бодисыг олборлодог улсын болон хувийн аливаа үйлдвэрийг хэлнэ.

(2) Уурхайд буюу газар доор ажиллах хүмүүсийн буюу тэдгээрийг ажиллуулах тухай энэхүү Зөвлөмжийн заалтууд нь газар доорх ажилд авах ба ажиллуулахад нэгэн адил хамаарна.

2. Уурхайд буюу газар доор ажилд авах ба ажиллуулах насны доод хязгаарыг 16 наснаас доош тогтоосон байвал уг хязгаарыг 16 нас болгох яаралтай арга хэмжээг нэн даруй авна.

3. (1) Уурхайд газар дор ажиллуулах, ажилд авах насны доод хязгаарыг аажим аажмаар дээшлүүлж 18 болговол зохино.

(2) Гишүүн орон бүр уурхайн газар доорх болзошгүй осол, аюул, түүнчлэн ирээдүйн уурхайчдыг сурган бэлтгэх зорилт, дунд сургууль төгсөж буй насны хамгийн доод хязгаар, үйлдвэрлэлийн бусад салбарт ажилд авч байгаа насны доод хязгаар зэргийг харгалзан энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан зорилтод хүрэхийн төлөө өөрийн улс орны боломжийн хүрээнд ажиллана.

4. Уурхайд буюу газар дор ажиллах хүмүүсийн насны доод хязгаарын тухай 1965 оны Конвенцид заасан болон орон тус бүрт тогтоогдсон насны доод хязгаар (18 наснаас доошгүй) хоёрын хоорондох насны хүмүүсийг дараахь тохиолдолд л уурхайд буюу газар дор ажиллуулбал зохино:

(a) тухайн ажлын талаар техникийн мэдлэгтэй, дадал туршлагатай эрх бүхий хүмүүсийн зохих хараа хяналтын доор дагалдангаар ажиллах, дадлага хийх болон тусгай сургалт явуулах;

(b) ажиллуулж байгаа газартай холбоотой эрх мэдэл бүхий байгууллагын зөвшөөрснөөр, түүнээс гаргасан нөхцлийн хүрээнд байнгын эрүүл мэндийн болон аюулгүй байдлын талаас үзүүлэх

болзлын доор, хэрвээ энэ зүйлд хамрагдаж байгаа залуу хүн дадлага, туршлага, сургалтын хугацаагаа дуусгасан бол тэрээр сургалтанд хамаарагдахаас өөр зорилгоор газар дор ажиллаж болно.

5. (1) Уурхайд буюу газар доор ажиллуулах насны доод хязгаартай холбоотой дараахь тусгай заалтууд байна:

(a) эрүүл мэндэд хортой тусгай ажил хийх талаар;

(b) эрүүл мэндэд хортой тусгай нөхцлийн дор ажиллахтай холбоотой;

(c) тухайн ажилчны болон бусад ажилчдын аюулгүй байдалд нөлөөлөх тусгай ажлын талаар зэрэг болно.

(2) Тухайн улсын эрх бүхий байгууллага нь хийх ажил, түүний нөхцлийн талаар тэнд ажиллах хүнээс өөрөөс нь асууж байж тогтоох бөгөөд ямар ч тохиолдолд ажиллах насны доод хязгаарыг 18-аас доошгүйгээр тодорхойлж өгвөл зохино.

6. (1) Хэрэв сургууль төгсөх насны доод хязгаараас дээш настай аливаа нэг хүн уурхайд ажиллахыг хүсвэл түүний хүсэлтийг биелүүлэх талаар эрх мэдэл бүхий байгууллагаас зохих арга хэмжээг авбал зохино. Ийм арга хэмжээнүүд нь улс орон даяар залуучуудад боловсрол олгох, сургах болон дайчлах бодлоготой нягт уялдсан байвал зохино.

(2) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу авах арга хэмжээнүүд нь дор дурдсан зүйлийг дурдсанаас илүү тааламжтай байдлаар багтаасан байж болно:

(a) зохих сургалттай хослуулан газрын дээрх ажилд ажиллуулах;

(b) тухайн хүмүүсийг ирээдүйн мэргэжилд нь бэлтгэх үүднээс газрын дээр тусгай сургалт явуулах;

(c) цаашдын боловсролыг харгалзах буюу мэргэжлийн дагуу тусгай зөвлөгөө өгөх;

(d) сургууль төгсөх насны доод хязгаарыг дээшлүүлэх.

7. Тухайн улсын эрх бүхий байгууллага нь энэхүү Зөвлөмжийн зарчмуудтай нийцсэн журам гаргах болон уг зарчмуудыг хэрэгжүүлэх ерөнхий бодлогыг боловсруулан гаргахын өмнө холбогдох эздийн болон ажилчдын төлөөллийн хамгийн дээд байгууллагатай хэлэлцэн зөвшилцсөн байна.

34. ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ АЖИЛЧДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ БОЛОН ТЭДЭНД ОЛГОГДОХ БОЛОЛЦООНЫ ТУХАЙ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 135 ДУГААР КОНВЕНЦ

*1973 оны 6 дугаар сарын 23-ны өдөр баталж,
1973 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон**

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,
Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1971 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан тавин зургаадугаар чуулганаараа,

ажилчдын мэргэжлийнхээ салбарт эвлэлдэн нэгдэхэд алагчилах аливаа үйлдлээс хамгаалсан Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 1949 оны конвенцийн заалтыг харгалзан, тэдгээрт ажилчдын төлөөлөгчдөд хамаарах нэмэлт оруулах шаардлагатайг анхаарч,

Чуулганы хэлэлцэх хэргийн 5 дахь асуудал болох үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийг хамгаалах, ажил хөдөлмөрөө явуулахад нь бололцоо олгох тухай тодорхой саналыг конвенцийн хэлбэрээр гаргахаар шийдвэрлэж,

нэг мянга есөн зуун далан нэгэн оны зургаадугаар сарын хорин гуравны энэ өдөр дараахь конвенцийг Ажилчдын төлөөлөгчдийн тухай 1971 оны конвенц гэж нэрлэхээр тогтон батлав:

1 дүгээр зүйл

Үйлдвэрийн газар дахь ажилчдын төлөөлөгчдийн үйл ажиллагаа дагаж мөрдөж буй хууль тогтоомж, хамтын гэрээ эсхүл хамтран тохиролцоонд хүрсэн бусад нөхцөлд хамтын хэлцэлд нийцсэн бол тэдгээрийг ажилчдын төлөөлөгчид, эсхүл ажилчдыг төлөөлж үйл ажиллагаа явуулсан, үйлдвэрчний эвлэлийн гишүүн, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаанд оролцсон шалтгаанаар ажлаас халах мэтээр хохироох үйлдлээс үр нөлөөтэй хамгаална.

2 дугаар зүйл

1. Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчид ажил үүргээ шуурхай, үр ашигтай гүйцэтгэх бололцоогоор хангагдана.

2. Үүнтэй холбогдон тухайн орны хөдөлмөрийн харилцааны тогтолцооны онцлог, тухайн үйлдвэрийн газрын хэрэгцээ, хэмжээ, чадавхийг харгалзан үзнэ.

3. Ийм бололцоо олгох нь тухайн үйлдвэрийн газрын үр ашигтай үйл ажиллагаанд саад болох ёсгүй.

3 дугаар зүйл

* 1995.05.29-ia iyäaäyi iðñii

Энэхүү Конвенц дахь “ажилчдын төлөөлөгчид” гэсэн нэр томъёо нь үндэсний хууль тогтоомж буюу дадал болон хүлээн зөвшөөрөгдсөн дараахь хүмүүст хамаарна:

(a) үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид, тухайлбал үйлдвэрчний эвлэл буюу түүний гишүүдээс сонгогдсон буюу томилогдсон төлөөлөгчид, эсхүл

(b) сонгогдсон төлөөлөгчид, тухайлбал, үндэсний хууль тогтоомж, хамтын гэрээний заалтын дагуу ажилчдаас чөлөөтэй сонгогдсон, тухайн улсын үйлдвэрчний эвлэлийн байгууллагад тусгайлан олгогдсон чиг үүрэгт хамаарахгүйгээр үйл ажиллагаа явуулах төлөөлөгчид байна.

4 дүгээр зүйл

Үндэсний хууль тогтоомж, хамтын гэрээ, арбитр болон шүүхийн шийдвэрт энэхүү Конвенцид заасан бололцоогоор хангагдах, хамгаалуулах ажилчдын төлөөлөгчдийн ангиллыг тогтоож болно.

5 дугаар зүйл

Тухайн үйлдвэрийн газарт үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид болон хамт олны дундаас сонгогдсон төлөөлөгчдийн аль аль нь байгаа тохиолдолд сонгогдсон төлөөлөгчдийг холбогдох үйлдвэрчний эвлэл, түүний төлөөлөгчдийн байр суурийг сулруулах зорилгоор ашиглахгүй байх, түүнчлэн холбогдох бүхий л асуудлаар сонгогдсон төлөөлөгчид болон үйлдвэрчний эвлэл, түүний төлөөлөгчдийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ.

6 дугаар зүйл

Энэхүү Конвенцийг үндэсний хууль тогтоомж, хамтын гэрээ буюу үндэсний дадал болсон зүйлд нийцсэн бусад арга замаар хэрэгжүүлж болно.

7 дугаар зүйл

Энэхүү Конвенцийг соёрхон батласан тухай албан ёсны батламж жуух бичгийг Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд бүртгүүлэхээр хүргүүлнэ.

8 дугаар зүйл

1. Энэхүү Конвенц нь соёрхон батласан тухай батламж жуух бичгийг Ерөнхий захиралд бүртгүүлсэн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн улсуудын хооронд үйлчилнэ.

2. Энэхүү конвенц нь Ерөнхий захирал гишүүн хоёр улсын соёрхон батласан тухай батламж жуух бичгийг бүртгэснээс хойш арван хоёр сарын дараа хүчин төгөлдөр болно.

3. Түүнээс хойш энэхүү Конвенц аливаа гишүүн улсын хувьд соёрхон батласан тухай батламж жуух бичгийг бүртгүүлсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараа тус тус хүчин төгөлдөр болно.

9 дүгээр зүйл

1. Энэхүү Конвенцийг соёрхон батласан аливаа гишүүн улс түүнийг анх хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван жилийн дараа конвенцийг цуцлах тухай мэдэгдлээ Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захиралд бүртгүүлснээр Конвенцийг цуцалж болно. Цуцлалт тухайн хүсэлтийг бүртгэснээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Конвенцийг соёрхон батласан аливаа гишүүн улс өмнөх хэсэгт дурдсан арван жилийн хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор энэ зүйлд заасан Конвенцийг цуцлах эрхийг хэрэгжүүлээгүй тохиолдолд дараагийн арван жилийн хугацаанд уг конвенцийг дагаж мөрдөх бөгөөд цаашид энэ зүйлд тодорхойлсон журмын дагуу арван жил дуусах бүр тус Конвенцийг цуцлах эрхтэй байна.

10 дугаар зүйл

1. Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гишүүн улсаас хүлээн авсан соёрхон батласан тухай батламж жуух бичиг, мэдэгдэл болон цуцлалтын бүртгэлийн тухай гишүүн улс бүрт мэдэгдэнэ.

2. Ерөнхий захирал соёрхон батласан тухай хоёр дахь батламж жуух бичгийг хүлээн авч бүртгэсэн талаар байгууллагын гишүүн улсад мэдэгдэхдээ энэхүү Конвенц хүчин төгөлдөр болох он, сар, өдрийг сануулна.

11 дүгээр зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Ерөнхий захирал өмнөх зүйлүүдэд заасан журмаар бүртгэсэн соёрхон батласан тухай батламж жуух бичиг, мэдэгдэл болон цуцлалтын тухай бүх мэдээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлд заасан ёсоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бүртгүүлэхээр хүргүүлнэ.

12 дугаар зүйл

Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөл шаардлагатай хэмээн үзвэл энэхүү Конвенцийн хэрэгжилтийн талаар Ерөнхий бага хуралд илтгэн, улмаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Бага хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл

1. Энэхүү Конвенцийг бүхэлд нь буюу зарим хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулсан шинэ конвенцийг Бага хурлаар баталж, тэрхүү конвенцид өөрөөр заагаагүй бол:

(а) Нэмэлт өөрчлөлт оруулсан шинэ конвенц хүчин төгөлдөр болох тохиолдолд аливаа гишүүн улсын хувьд түүнийг соёрхон баталмагц энэхүү конвенц нь дээрх 9 дүгээр зүйлийн заалтыг үл харгалзан нэн даруй /ipso jure/ хүчингүй болно.

(б) Өөрчлөлт оруулсан шинэ конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн энэхүү Конвенцийг гишүүн улсууд соёрхон батлахгүй.

2. Энэхүү Конвенц нь түүнийг соёрхон батласан бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулсан шинэ Конвенцийг соёрхон батлаагүй гишүүн улсын хувьд ямар ч тохиолдолд хэлбэр, агуулгын хувьд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

14 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн англи, франц хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

35. ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ АЖИЛЧДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ БОЛОН ТЭДЭНД ОЛГОГДОХ БОЛОЛЦООНЫ ТУХАЙ 143 ДУГААР ЗӨВЛӨМЖ

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий бага хурал нь,
Олон улсын хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 1971 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан тавин зургаадугаар чуулганаараа,

Ажилчдын төлөөлөгчдийн тухай 1971 оны конвенцийг баталж,

Чуулганы хэлэлцэх хэргийн тав дахь асуудал болсон Үйлдвэрийн газар дахь ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах, тэдэнд бололцоо олгохтой холбогдсон тодорхой саналуудыг хэлэлцэж, тэдгээр саналыг зөвлөмжийн хэлбэрт оруулахаар тогтож,

нэг мянга есөн зуун далан нэгэн оны зургаадугаар сарын хорин гуравны энэ өдөр дараахь зөвлөмжийг Ажилчдын төлөөлөгчдийн тухай 1971 оны зөвлөмж гэж нэрлэхээр тогтон батлав:

1. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

1. Энэхүү Зөвлөмж нь тухайн улсын үндэсний дадалд нийцсэн үндэсний хууль тогтоомж болон хамтын гэрээгээр буюу бусад арга замаар хэрэгжинэ.

2. НИЙТЛЭГ ЗААЛТ

2. Энэхүү Зөвлөмжийн зорилгод “ажилчдын төлөөлөгчид” гэсэн нэр томъёо нь үндэсний хууль буюу дадлын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсийг хэлэх бөгөөд тэдгээр нь: